

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ванчигийн Нямчулуун	Дугаар	L196
Оршин суугаа аймаг	Завхан	Оршин суугаа сум	Тэлмэн сум, Баянтэгш баг
Төрсөн газар	Тэлмэн сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бэлчирийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ЗАТЛ 052
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 23	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх

Завхан аймгийн Тэлмэн сумын Бэлчирийн хүрээ

Нямчулуун: За би энэ нутаг усанд төрж өсөөд жар гаран, дал шахуу жил амьдарч байна. Энэ нутаг усыг нэлээн мэдэх гадарлах хүний нэг нь би юм аа. За энд одоо ардын хувьсгал гээч юмаас өмнө Сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошуу, Бирваа бэйсийн хошууны ард иргэдийн дундын Бэлчирийн хүрээ гэдэг нэртэй ийм хүрээ. Яг хэдэн онд байгуулагдсаныг нь би сонсоогүй ээ. За 1922 буюу 1931, 1932 оныг энд тийм хүрээ байсан. За тэгээд тэрүүнийг би та бүхэндээ зааж өгч хэмжээ хязгаарыг нь хүртэл та бүхэн авлаа. Тэгээд одоо ардын хувьсгал үүссэн үед энэ хүрээ хийдийг устгаж лам хуваргуудыг нь баривчлах буюу алах, дуган шүтээнийг нь галдаж шатаах, буулгаж нураах ийм ажил асуудлууд хийгдэж байсан юм гэнэ лээ. Намайг төрөхөөс арваад жилийн өмнө. Тэгээд одоо дараа нь би энд төрсөн. Эцэг өвгөд ах дүү нарын ярианаас дуулж сонссон. Үлдэгдэл шатаагүй байсан барилгыг нь Тэлмэн сумыг 1932 онд байгуулагдах үед зарим барилгыг нь үхэр тэргээр зөөж Тэлмэн сумын төвд аваачиж худалдаа бэлтгэлийн ангийн скалад болгочихсон барилга байсныг би мэдэх юм аа. Аранжин гэдэг хүн байсан юм гэнэ лээ. Гэсгүй лам нь Малхын Үлэмжбаяр гэдэг лам байсан гэлцдэг юм. Тэгээд л Ванчин гавж гэх мэтийн, Пэрэнлэй унзад гэх мэтийн олон лам хуваргууд энд аж төрөн амьдарч бурхан номын үйл үйлдэж байсан гэсэн ийм домог яриаг би сонссон юм аа. Одоо нэг 20 гаран лам хуваргууд байсан юм гэнэ лээ, цөөхөн лам хуврагтай байсан юм шиг байгаа юм. Тэгэхдээ юм юм л байдаг байсан. Хоёр гол дуган байдаг байсан гэж би сонссон юм байгаа юм. Нэг нь лав цогчин дуган байсан гэдэг юм. Нөгөөдөхийг нь одоо юуны дуган байсныг уг нь дуулж байсан юм, одоо мартаж орхиж. Энд цам майдар гээч юм эргэж байсан гэж хөгшчүүл маань ярьдаг байсан. за тэр Лхам гэдэг бурхныг гол сахиусаа болгож байсан гэсэн гэж бодогдож байна. За ийм л байна даа, миний мэдэх юм.